



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2004 оны 7 сарын 27 өдөр

Дугаар 247

Улаанбаатар

Гадаадад суралцуулах тухай

“Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс”-ын 2004 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн хурлын тэмдэглэл, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам”-ын 2,6-г үндэслэн ТУШААХ НЬ:

1.Ганбат овогтой Батбилэгтийг 2004-2005 оны хичээлийн жилээс АНУ-ын Өмнөд Дакотагийн Их сургуулийн магистрантурт төрийн захиргааны удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаагаар суралцуулсугай.

2.Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан “Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам”-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2004 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 240 дугаар тушаалын Ганбат овогтой Батбилэгтэй холбоотой хэсгийг хүчингүйд тооцсугай.

140
“Тушаалд квалификаци хийгдээ”

САЙД

А.ЦАНЖИД

0000755